



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/227

Хэрлэн сум

Биеийн тамир спортын газарт  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Биеийн тамир спортын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу XVII жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээгч харагчин туулай жилийн сар шинийн барилдааны зардалд 5,345,000 (таван сая гурван зуун дөчин таван мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх" зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дугаар сарын 14-ны өдрийн  
А/227 дугаар захирамжийн хавсралт

### БӨХИЙН БАРИЛДААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Бөхчүүдийн бай шагналд зарцуулах зардлын төсөв

| №  | Бөхийн даваа | Бөхийн тоо | Нэг бүрийн үнэ | Нийт       |
|----|--------------|------------|----------------|------------|
| 1  | Нэг давсан   | 8          | 85.000         | 680.000    |
| 2  | Хоёр давсан  | 4          | 150.000        | 600.000    |
| 3  | Шөвгөрсөн    | 2          | 350.000        | 700.000    |
| 4  | Үзүүрэлсэн   | 1          | 500.000        | 500.000    |
| 5  | Түрүүлсэн    | 1          | 1.000.000      | 1.000.000  |
| 6  | Гарын даа    | 3          | 85.000         | 255.000    |
| 7  | Хөлын цэц    | 3          | 85.000         | 255.000    |
| 8  | Засуул       | 8          | 85.000         | 680.000    |
| 9  | Тайлбарлагч  | 1          | 85.000         | 85.000     |
| 10 | Нийт         |            |                | 4.755.000₮ |

Өсвөр бөхийн барилдааны зардлын төсөв

| № | Бөхийн даваа | Бөхийн тоо | Нэг бөхийн шагнал | Нийт     |
|---|--------------|------------|-------------------|----------|
| 1 | Нэг давсан   | 4          | 50.000            | 200.000  |
| 2 | Хоёр давсан  | 2          | 85.000            | 170.000  |
| 3 | Үзүүрэлсэн   | 1          | 110.000           | 100.000  |
| 4 | Түрүүлсэн    | 1          | 120.000           | 120.000  |
| 5 | Нийт         |            |                   | 590.000₮ |

Нийт төсөв-5.345.000₮